



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 5/15

Баянхутаг сум

**Б.Бат-Эрдэнийг Бэлчээр, газар тариалангийн
асуудал хариуцсан
мэргэжилтнээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.3, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам", Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны Арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймгийн салбар зөвлөлийн 2024 оны 04 сарын 08-ны өдрийн 47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтанд тэнцсэн Б.Бат-Эрдэнийг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс томилсугай.

2. Б.Бат-Эрдэнийн сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэлээр тогтоон, 1210000 /нэг сая хоёр зуун арван мянга/ төгрөгөөр тооцож, холбогдох бусад нэмэгдлийг хууль, журманд заасны дагуу олгохыг Нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нярав

4. Албан тушаалын тодорхойлолтонд заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗОЛБОО

А:0034 30740